



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 5/76

Хэрлэн сум

Ч.Пүрэвдоржийг түр орлон гүйцэтгэгчээр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Засгийн газрын 2011 оны 62 дугаартай тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.4, 4.3, 4.3.3, 4.4, 5.3 дахь заалт, 2007 оны 354 дүгээр тогтоолын 1 дүгээр, 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Чүүрэнгийн Пүрэвдоржийг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ч.Пүрэвдоржийн үндсэн цалинг ТЗ-9-1 шатлалаар 691610 /зургаан зуун ерэн нэгэн мянга зургаан зуун арван/ төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар тооцож олгохыг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн нягтлан бодогч /З.Баасандаш/-д зөвшөөрсүгэй.

3. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ч.Пүрэвдоржид үүрэг болгосугай.

4. Ч.Пүрэвдоржид томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА